



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 214

Улаанбаатар
хот


Талбайг нөөцөөс чөлөөлөх тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 13.4.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Талбай нөөцөд авах, хайгуулын ажил хийх тухай” Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 128 дугаар тогтоолын хавсралтад заасан улсын төсвийн хөрөнгөөр геологи хайгуулын ажил хийх зорилгоор нөөцөд авсан талбайг нөөцөөс чөлөөлсүгэй.

2. Нөөцөөс чөлөөлсөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших “Оюут уул”, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутагт орших “Эрдэнэт-Зүүн хойд-3” талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Ашигт малтмалын газрын дарга Д.Үүрийнтуяад даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Талбай нөөцөд авах, хайгуулын ажил хийх тухай” Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 128 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Уул уурхайн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Р.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙН
ЯАМ

Бүрт №... 1437

С. 2016.04.27

... минутанд

Сайт д шилжүүлэв.

74